

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2022 оны 4 сарын 30-ны өдөр;

Хурлын байршил: Хан-Уул дүүрэг 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Улаанбаатар хот Корпорэйт зочид буудал, Конвешн Центр

Хурал эхэлсэн цаг: 11:30 цаг;

Хурлын дарга: Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид “ТУЗ”гэх)-ийн дарга Ч.Ганхуяг;

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2020 оны ногдол ашгийн тайлан болон 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
4. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах - “Компанийн албан ёсны бүртгэлийн хаяг өөрчлөх”;
6. Давуу эрхийн хувьцаа гаргахыг зөвшөөрөх;
7. Хоёрдогч өглөг гаргахыг зөвшөөрөх;

1. Хурлын ирц бүртгэх, Бүртгэлийн үйл ажиллагааны үр дүнг гаргах, тайланг танилцуулах

Хурлын ирц: 227,664,474 ширхэг хувьцаа буюу хувьцаа эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 81,34 %-ийн ирцтэй, хүчинтэй.

Танилцуулга хийсэн: Тооллогын комиссын дарга Г.Алтансүх

Хурлын дарга Ганхуяг: Манай Алтансүх бид хоёр гурав дахь хурлаа хийж байгаа шүү өнөөдөр. Гурван удаа тоолоод жоохон толгой нь эргэлдсэн байвал уучлаарай. Дөнгөж сая нэг түүхэн шийдвэрийг тоолчихоод ирсэн тийм ээ? Өөрийгөө танилцуулаад эхэлчих үү?

Тооллогын комиссын дарга Алтансүх: Блүмсбюри Секьюритис ҮЦК-ийн ажилтан байна. Одоо тооллогын комиссын даргаар ажиллаж байгаа. Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 22/01 хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн баталгаажилт. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь: Саналын эрх бүхий энгийн хувьцааны 227,664,474 ширхэг буюу 81,3 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь хэсгийг үндэслэн хурал хүчин төгөлдөр болсныг мэдэгдье.

2. ХЭХ-ийн нээлт, Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх

Танилцуулга хийсэн: Хурлын дарга Ч. Ганхуяг

Хуралдаа оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Намайг Чулууны Ганхуяг гэдэг. Би Ард Кредит ББСБ-ын ТУЗ-ийн даргаар 2013 оноос хойш анхны хөрөнгө оруулалтаа хийгээд, тасралтгүй ажилласан байна. Энэ удаад бид ээлжит бус хурлуудыг оруулахгүйгээр 3 дахь удаагаа нээлттэй компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж байгаа юм байна. Бид 2019 оны 3 байна уу, 4 сард нээлттэй хувьцаат компани болж байсан. Анхны ББСБ болж байсан. Ард Кредит гэдэг ББСБ ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэн байгаа биеэрээ оролцож байгаа мөн онлайнаар оролцож байгаа Ард апп-аараа саналаа өгч байгаа нийт нөхөддөө талархал илэрхийлье. Өнөөдөр энэ хурлын зохион байгуулахад гар бие оролцоод ажилласан

удирдлагын багийнхандаа, хуралдаа оролцож байгаа манай удирдах зөвлөлийн гишүүд та бүхэндээ бас талархал илэрхийлье. Хурлын ажилд амжилт хүсье.

Ингээд цөмөөрөө хурлаа нээх үү? Хурлаа нээхээс татгалзаж байгаа хүн байна уу? Нэг жилээр хойшлуулчихъя гэсэн хүмүүс? Байхгүй биз дээ? За ингээд хурал нээсэнд тооцлоо. Дэг бол ерөнхийдөө ийм байна. Цөмөөрөө хурлаа нээхээд хэлэлцэх асуудал дээр 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Тэлмэн, Хараат бус аудитын дүгнэлтийг Грант Торнтон Аудитын Компани, 2020 оны ногдол ашгийн тайлан, ногдол ашгийн шийдвэрийг манай ТУЗ-ийн гишүүн Одбаяр, Үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн Чинзоригт танилцуулах юм байна. Компанийн дүрэм дээр нэмэлт өөрчлөлт хийх юм байна шүү манайхаан. Энэ талаар манай Гүйцэтгэх захирал Тэлмэн танилцуулах юм байна. Давуу эрхийн хувьцаа гэгчийг цөмөөрөө гаргана. Хоёрдогч өглөг гэдэг зүйлийг гаргана. Үүнийг тухайн үед нь танилцуулан шүү. Ер нь давуу эрхийн хувьцааг нээлттэй ББСБ Монголын хөрөнгийн зах зээл дээр гаргаж байсан түүх байхгүй байгаа. Ер нь давуу эрхийн хувьцаа гаргаж байсан түүх байхгүй. 30 жил ажилласан бирж дээр. Өнөөдөр манайхаан түүхэн шийдвэр гаргах нь байна шүү. Хариуцлагатай хуралдаа оролцохыг урья. За тэгээд асуулт хариултуудаа явуулна. Гэхдээ би даргын хувьд та бүхэнд тайлангаа явуулчихаад, асуулт хариултаа явуулчихаад, асуудлуудаа танилцуулаад, шийдэж буй асуудлуудаараа асуулт хариултуудаа хоёр, гурван хэсэгтэйгээр явуулчихвал илүү дөхөмтэй байх. Манай онлайнаар оролцож байгаа нөхдүүд комментоор, мессежээр ирэх байх, Ард апп-аараа санал хураалтаа явуулчихна. Блүмсбюри гэдэг компанийн Алтансүх гэдэг залуутай бид өглөөнөөс хойш 3 дахь хурал дээрээ хамтраад ажиллачхаж байна. Манай хүн жоохон ядарсан байж магадгүй. Тооллогын комисс тэнд ажиллаж байгаа юм байна. Бүх юм цахимаар явчихаж байгаа. За тэгээд санал хураалтыг тоолоод, санал хураалтын дүнг нэгтгээд, тогтоолын төслүүдээ та бүхэндээ танилцуулаад батлуулаад хурлаа хаана. Миний танилцуулсан хэлэлцэх асуудал, дэгтэй холбоотой асуулт байна уу? Батлахгүй эсэргүүцэж байна гэсэн хүмүүс нь гараа өргөх үү? Бүгд дэмжиж байгаа гэж ойлгож болох уу? Тэгвэл 100 хувийн саналаар цөмөөрөө саяны хурлын дэг, хэлэлцэх асуудлыг баталсан гэж тооцье. Хурлынхаа ажиллагаанд орох уу?

Би нэг нээлт хийх ёстой юм шиг байна лээ тийм ээ?

За Ард Кредит ББСБ бол Монголын хөрөнгийн бирж дээр анхны ББСБ болоод гараад ирсэн. Монгол Улсад 500 гаруй ББСБ үйл ажиллагаа явуулаад байгаа гэж ярьдаг. Тэр компаниуд бол гэр бүлүүдээрээ, найз нөхдөөрөө, хувиараа ББСБ эхлүүлээд үйл ажиллагаа явуулдаг. Манайх юугаараа онцлогтой гэвэл та бидний компани шүү. Цөмөөрөө нийлээд ББСБ нийлээд ажиллуулж байгаа. Бид эдний анхныхыг нь 1998 онд Хөгжлийн алтан сан гэж байгуулж байсан бол тэр маань хувьсаад Хас банк болсон тэр түүхээр, жимээр, замналаар бид явж байна гэсэн үг. Ард Кредит гэдэг ББСБ. Бид 2013 онд энэ компанийг байгуулж байсан бол өнөөдөр зах зээл дээр жижиг, томоороо 6-д гараад ирсэн байна. Гэхдээ Монголдоо Монголбанкны цахим мөнгөний зөвшөөрөлтэй, СЗХ-ноос зээл, хадгаламж, гадаад валют солих, мөнгө гуйвуулах зөвшөөрлүүдийг бүгдийг нь авчихсан байдаг цөөхөн ББСБ-ын нэг. Цахим мөнгөний Ard Cash зөвшөөрөлтэй. Өнөөдөр тоогоороо бол бид нэг, хоёрт орж явна. Яагаад гэвэл Ард апп дээр гарч байгаа зээл, түүн дээр орж байгаа гүйлгээнүүдийг бүгдийг нь Ард Кредитийн зөвшөөрлөөр явуулж байна гэсэн үг. Бид өнөөдөр хийж болох бүх ашигт төвшиндөө бас хүрээгүй ээ гэж харж байгаа. Яагаад гэвэл бид өнөөдөр Ард апп дээр явж байгаа гүйлгээнүүд дээр татаас үзүүлдэг Ард Кредит. Гэхдээ Ард Кредит бол ашигт ажиллагаагаараа түрүү жил банк бусын салбартаа дээгүүр толгой цохиод гараад ирсэн. Мэдээжийн хэрэг Ард Апп-аар салбаргүй байдлаар бид банкны үйл ажиллагаа явуулж байгаа. Салбаргүй банк гэдэг маань өнөөдөр дараачийн шатанд танилцуулагдана. Бид нар Метаверс гээд Виртуал салбарыг та бүхэндээ танилцуулах болно. Бүх утгаараа яаж ч харсан Ард Кредит бол Ард Санхүүгийн Нэгдлийн толгой манлай компани. Бид Ард Кредитийн зөвшөөрөл, Лицензийн хүрээнд маш олон ажлыг амжуулж ирсэн бол дараачийн шатны ажлуудаа мөн төлөвлөөд явуулж байна гэж ойлгож болно. Ард Кредит бол одоо тэсэрсэн өсөлтийг гаргах боломжтой түвшинд хүрч байна. Ялангуяа өнөөдөр давуу эрхийн хувьцаа гаргах, хоёрдогч өглөгийг гаргах

зөвшөөрлүүдийг өгчихвөл компаниа цөмөөрөө цааш нь нэг, хоёр жилдээ санаа зовохгүйгээр өсгөх боломж гараад ирж байгаа. Мэдээжийн хэрэг Ард Кредитийн хувьд гол хувьцаа эзэмшигч бол Ард Санхүүгийн Нэгдэл. Манайханд Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигч байгаа юу? Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа байхгүй хүмүүс байна уу? Тэр алдааг засъя. Хэдхэн байна. Өнөөдөр л ер нь залруулъя. Ард Санхүүгийн Нэгдэл бол бид нар ашиг сонирхол нэгтэй толгой компани руугаа. Бид Ард Кредитийн талаас дээш хувийг эзэмшиж байгаа. Гэхдээ Ард Санхүүгийн Нэгдэл өөрөө олон арван мянган хувьцаа эзэмшигч цаанаа байдаг учир Ард Кредитийн хувьцаа эзэмшигч 15,000 гэж харж болохгүй. Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчид нийлээд 25,000 уулаа Ард Кредитийн хувьцааг давхар эзэмшиж байна гэсэн үг. Та бүхний өнөөдөр хуралдаа оролцож байгаа оролцоо, тэр итгэлийг улам баталгаажуулж байна. Ингээд хувьд бол манай ТУЗ, манай хувьцаа эзэмшигчид, манай гүйцэтгэх удирдлагын хамтын ажиллагаа бидний цаашид төлөвлөөд байгаа ажлыг бүгдийг нь амжилтад хүргэнэ гэдэгт 100 хувь итгэлтэй байна. Хуралдаа амжилт хүсье. Хуралдаа идэвхтэй оролцоорой. Манайхан асуух зүйл байвал, эргэлзэж байгаа зүйл байвал асуугаарай. Цөмөөрөө түүхэн Ард Кредит ББСБ ХК-ийн хувьд, Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд түүхэн нэг, хоёр шийдвэрүүдийг гаргана. Баярлалаа. Манай Тэлмэн дарга намайг урьж гарга гэж байна. /инээв/ Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал ноён Тэлмэн.

3. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах

Танилцуулга хийсэн: Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн

Баярлалаа. Юуны өмнө бүгдэд нь Ард Кредит хувьцаат компанийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын мөн баярын мэнд хүргэе.

Яах аргагүй баяр. Яагаад гэхээр бид 2021 оныхоо үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцана. Амаргүй жил байсан. Гэхдээ бид боломжийн сайхан ажилласан болов уу гэдгийг та бүхэн маань тайлангаас харах болов уу гэж бодож байна. Миний хувьд бол анх удаагаа Гүйцэтгэх захирлын хувьд нийт хувьцаа эзэмшигчидтэйгээ амьдаар, биетээр уулзаж байна. Товчхон өөрийгөө танилцуулъя. Намайг Гэрэлт овогтой Тэлмэн гэдэг. 2020 оны 1 сарын 27-ны ТУЗ-ийн тогтоолоор 2 жил 3 сарын өмнө Ард Кредит компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдоод яг Ковидын 2 жил та бүхэнтэйгээ зайнаас онлайнаар, зайнаас, лайваар уулзаж тайлангуудаа тавьж ажиллаа. Харилцагчидтайгаа хүртэл бид зайнаас ажиллах ийм он жилүүд байлаа. Өнөөдрийн энэ өдрийг бол ямар ч байсан ирнэ гэдгийн мэдэж байсан. Өнөөдөр энэ өдөр тохиож байгаад миний хувьд баяртай байна. ТУЗ дарга маань нэлээд дэлгэрэнгүй олон зүйлийг ярьчихсан учраас миний хувьд тайлангийн хувьд бүгдийг бус чухлыг нь дурдаад явчихъя.

2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг ярихаас өмнө эхлээд 2021 оны орчин нөхцөл ямар байсан бэ гэдгийг эргээд харах ёстой. Бид 2021 онд Ковидтой, хөл хориотой орчинд ажиллахаа ойлгож байсан. Тэр утгаараа компанийн хувьд зорилгоо бол хямарлыг давж боломжийг бий болгоно гэж тавьж орж ирсэн байгаа. 2021 оны эхний хагасын гуравны хоёрт нь 4 удаагийн хатуу хөл хорио тавьж, хүмүүс Ковидоор өвдөж байсан ийм үе байсан. Бидний хувьд хамгийн түрүүнд нийт ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах асуудал байсан. Гэсэн хэдий ч нийт ажиллагсдын 80 хувь нь Ковидоор өвдсөн, эдгэсэн, буцаад ажилласан. Бид бизнесийн тасралтгүй үйл ажиллагаагаа хангахыг хичээж ажиллаа. Түүний нэгэн адил яг хөл хорионы үед цахимаар олон мянган зээлийн гэрээг хийх шаардлага үүссэн. Тэр утгаараа үйлчилгээгээ хүргэж байлаа. Ковидын нөхцөлд үйлчилгээний салбарууд асар хүнд байдалд орсон та бүхэн мэдэж байгаа. Нийт сая гаруй цалин авч татвар төлдөг иргэд байдаг бол түүний 50 хувь нь үйлчилгээний салбарт ажилладаг. Эдгээр хүмүүст ирж байгаа төлбөрийн дарамтыг яаж бууруулж болох, энэ үеийг яаж хамтдаа давж гарч болох юм бэ гэдэг дээр нэлээн төвлөрч ажилласан. Тэр хүрээнд зээлийг хүүг бууруулж, авах ёстой санхүүгийн тодорхой асуудлыг шийдэхийн тулд хэмжээгээ нэмэгдүүлж ажилласан. Энэ нь ч 2021 оны эцсийн үр дүнд бол зөв шийдвэр байсан юм байна гэдгээр гарч ирж байгаа. Ард апп-ыг та бүхэн мэдэж байгаа Ард Санхүүгийн Нэгдлийн өмч, Ард Кредит оролцогч гэхдээ Ард апп-ыг 1 сая харилцагчтай болоход Ард Кредит асар том үүрэгтэй оролцсон. Бид 2020 оны эцэст 300 мянган харилцагчтай байсан бол

2021 онд 1 саяд хүрсэн байдаг. Компани маань 2011 онд 10 жилийн өмнө жижигхэн уламжлалт зээлийн үйл ажиллагаа явуулдаг ББСБ байсан бол өнөөдөр 10 жилийнхээ ойг өнгөрсөн жил тэмдэглэлээ. 10 жилийнхээ ойг тэмдэглэхэд компани маань салбартаа 534 ББСБ-аас хөрөнгө, активаараа 6-д, түрүүн ТУЗ-ийн даргын хэлсэнчлэн дан ганц СЗХ биш Монголбанкнаас авсан тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд Үндэсний төлбөрийн системийн оролцогч болчихсон. Өнөөдөр Ард апп-ын бид банкны дайтай дутахгүй, зарим талаараа магадгүй олон талаараа илүү апп шүү гэдгийн хэлээд байгаа. Төв шууданд нэг салбараа нээсэн байгаа. Очиж үйлчлүүлсэн хүмүүс байна уу? Төв шуудангийн 100 жилийн ой өнгөрсөн жил болсон. Манай группийн зүгээс уг ойд нь бэлэг бариад маш гоё засвар хийж өгсөн байгаа. Тэнд манай салбар нээгдсэн байгаа та бүхэн очиж үйлчлүүлээрэй. Бид 2021 онд бүх аймагт хүрч ажиллая гэсэн түүндээ ч хүрсэн. Бүх аймгуудад бид зээлийн үйл ажиллагаагаараа нэвтэрсэн байгаа. Гадаад санхүүжилтийн өртгийг бууруулж, дээрээс нь өсгөж чадсан байгаа. Ard Kids гээд апп. 3 давхарт бүүт нь байгаа та бүхэн зочлоод ороорой. 25,000 хүүхэд энийг ашиглаж байна. Ard Kids апп-ыг монголдоо анх удаа тусдаа апп-ыг нэвтрүүллээ. Энэ жил улам өргөжнө. Online зээлийн бүтээгдэхүүн гэхээр Ард апп, Fast cash-ыг та бүхэн мэдэж байгаа 2019 оноос хойш нэвтрүүлсэн. 2021 онд онлайнаар үйлчилгээ авах шаардлага их байгааг ойлгож байсан учир олон төрлийн төрөлжилтүүдийн хийж чадлаа. Та хэрвээ манай хувьцаа эзэмшигч бол тэр тусмаа түрүү жилийн 3 сард орж ирсэн дийлэнх хувьцаа эзэмшигч нар байгаа бид нар 2020 оны 12 сарын 31 буюу 2020 оны сүүлээр 2,139 хувьцаа эзэмшигчтэй байсан бол өнгөрсөн жил 13,000 болж хувьцаа эзэмшигчдийн тоо 4 дахин нэмэгдсэн. Манайд хувьцаа эзэмшигчдэд зориулсан Fast cash white гээд зээлийн бүтээгдэхүүн байгаа эхний 30 хоногтоо хүүгүй, дараачийн сараас хөнгөлөлттэй хүүгийн нөхцөлтэй. Энэ маань бараг Кредит картын төвшиний үйлчилгээ, нөхцөлийг та бүхэндээ олгож байгаа. Мэдээж хэрэг та магадгүй Ардын тэтгэврийн дансанд хуримтлалаа хуримтлуулдаг бол, Ард Активын хадгаламжид мөнгөө хадгалуулдаг бол манай итгэлцэл дээр мөнгөө хадгалуулдаг бол хадгаламж барьцаалсан зээлийг бас апп-аараа дамжуулан олгох боломжтой болсон байна. Өнгөрсөн жил бас нэг зүйл болсон. Бид арилжааны хувь хэмжээгээрээ, ашигт үйл ажиллагаа гээд олон үзүүлэлтээрээ Монголын хөрөнгийн бирж дээр 1 дүгээр ангилалд дэвшиж орсон байгаа. Хамгийн сайн хувьцаанууд байдаг. 3 дахь жилдээ IPO хийснээс хойш дараалан топ 20 индекс-д манайх багтаж байгаа.

Ажлын байрыг хадгалах нь түрүү жил олон газар сорилт байсан бол бидний хувьд бол нэмэгдүүллээ. Бид 34 болгосон буюу 30 хувь нэмэгдүүллээ. Энэ нь үйл ажиллагаа тэлснийг харж байгаа байх. Монголын банкны холбоонд гишүүн болсон байгаа. ББСБ-ын салбарын үзүүлэлтийг 2020, 2021 онд харуулчихъя. АрдКредит гайгүй байсан юм байна. Тэгвэл салбартаа хэр байсан юм бэ? гэдэг нь чухал үзүүлэлт. Бид магадгүй гэртээ гайгүй байгаад байгаа юм шиг мөртлөө гараад үзвэл ямар байгаа юм гэдгээ харах хэрэгтэй. ББС-ын салбарын гол үзүүлэлтүүд болох нийт орлого, нийт хөрөнгө, цэвэр ашгийн хэмжээ бол дунджаар 27.5-35.7 хувийн өсөлт 2021 онд үзүүлсэн. Дунджаар 30 хувьтай. Тэгвэл Ард Кредитийн хувьд ямар байсан бэ? гэхээр орлого маань 1,9 дахин буюу 190 хувь гэж ойлгож болно. Нийт хөрөнгө маань 2.5 дахин, 2020 онтой харьцуулахад цэвэр ашиг маань 3,3 дахин буюу 330 хувиар өссөн. Ногдол ашиг тараах шийдвэрийг ТУЗ гаргасан. Та бүхэнд баяр хүргэе.

Зээлийн гол үзүүлэлтүүдийг товчхон харуулъя. Бид бол зээлээ тогтмол олгосоор байсан. Зарим нэг байгууллагууд эрсдэлтэй нөхцөл орчин бүрдчихлээ зээл олгохоо зогсооё, хязгаарлая гэж байсан бол бид илүү тэлэлтийг хийсэн. 20.2 тэрбумаас 36.6 тэрбум төгрөг болж өссөн байна. Доор харагдаж байгаа цагаан багана нь бол Эрсдэлийн сан байгаа. Магадгүй хажууд байж байгаа шар чанаргүй зээлийн багцийг хамгаалах зориулалттай.

Зээлийн багц маань 20.2-36.6 тэрбум болсон байгаа. Чанаргүй зээлийг өсөөд ирэхээр уг эрсдэлээ хаахын тулд Эрсдэлийн сан байгуулдаг. СЗХ-ны шаардлагаар тавьсан. Бид уг шаардлагаас давсан байдлаар тэрбум төгрөгөөр илүү байгуулж явдаг. 2021 онд чанаргүй зээлийн багц 2.5 тэрбум, эрсдэлийн сан 2,4 тэрбум. Эрсдэлтэй багцаа бид 2020 онтой харьцуулахад 12,7-9.20 хувь, чанаргүй зээлийн багцаа 9.45-7.2 хувь болгосон байна. Энэ үед төр, захиргааны байгууллагаас зээлдэгчдийн хувьд хүндрэлтэй байгаа учраас хэвийн зээлийн хугацааг анх 120 хоног хугацаа хэтрүүлэх болгосон.

Дараа нь 90, 60, буцаагаад энэ жилийн 1 сарын 1-нээс 30 болгосон байдаг. Энэ үед буцаагаад ангилал маань чангарч байсан хэдий ч манай багцын чанар сайжирч байсныг эндээс харах хэрэгтэй.

Өнгөрсөн онд нийт 185 тэрбум төгрөгийн зээлийг иргэдэд болон ААН-д олгосон бол эргээд 68.6 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг хийсэн байна. 2020 онтой харьцуулахад 2 дахин илүү зээлийг олгосон байна.

Санхүүгийн гол үзүүлэлтүүдийг танилцуулья. 2022 оны нэгдүгээр улирал гарсан байгаа тул хамгийн сүүлд буюу 3 дахь багана дээр харуулчихсан байна. Нийт хөрөнгийн хэмжээ 29.6-73.3 тэрбум, зээлийн багц 20.2-36.6 тэрбум. Санхүүжилт маш чухал үүрэгтэй. Санхүүжилтийг татаж байж эдгээр өсөлтийг биелүүлдэг. 2020 онд 15 тэрбум санхүүжилт татаж байсан бол 2021 онд 38.7 тэрбум болж 2.6 дахин өссөн. Ингэснээр та бүгдийн эздийн өмчийг компани 2 дахин өсгөж 11.2-22.6 тэрбум болгожээ. Орлого үр дүнгийн тайланг товчхон танилцуулья. Хүүгийн орлого бол 7.7. Татварын өмнөх ашиг 4,5 тэрбумтай гарсан. Орлогын албан татварын зардлыг хассаны дараа цэвэр ашиг маань аудитлагдсан тайлангаар 3.9 тэрбум төгрөг болж гарч ирлээ. Орлого үр дүнгийн тайлангийн доод талын 2 багана дээр байгааг маш товчхон танилцуулахад компани маань дан гарц зээлийн үйл ажиллагаа явуулдаггүй. Түрүүн ТУЗ-ийн дарга маань хэлсэн БХХО-ын зөвшөөрөлтэй. БХХО хувьцаанд хийдэг. Мөн биет бус хөрөнгүүдэд хөрөнгө оруулалт хийдэг. Түүний дахин үнэлгээний үнэ цэнийн нэмэгдэл нь энэ дээр тусгаад 7.8 тэрбум. Ийнхүү нийт дэлгэрэнгүй ашиг 2021 онд 11.7 тэрбумтай гарсан байна.

Санхүүгийн байдлын тайлан. Компанийн нийт хөрөнгө 73.3 тэрбум болсон гээд хэлсэн. Түүнийг өсгөхөд ямар гол, гол үзүүлэлтүүд өссөнөөр нэмэгдсэн бэ? гэхээр түрүүн хэлсэнчлэн зээлийн багц, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө буюу манай дансанд байгаа мөнгө 6.9 тэрбум. Авлага дээр 20.5 тэрбум төгрөгийн авлага байгаа. Энэ дээр бид тодорхой биет бус хөрөнгө БХХО-ын хэрэгслийн хувьд өөр дээрээ байлгадаг. СЗХ-оос тодорхой, тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн шаардлага дээр хөрөнгөөр бүртгэх боломжгүй гэдэг үүднээс холбоотой компани руу шилжүүлж авлагын тодорхой хувийг шилжүүлж авлага дээр оруулж ирсэн байдаг. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд нэлээн чухал. Ер нь СЗХ-оос тавьсан шаардлагуудыг бид хангаж ажиллаж байж өнөөдрийн ХЭХ-аар гаргах давуу эрхийн хувьцаа, хоёрдогч өглөгийн зөвшөөрлийг авахад чухал байдаг. Дараа дараагийн бондыг авахад мөн чухал. Он гараад эхний улиралдаа 7 тэрбум төгрөгийн бондыг ББЗЗ-д гаргах болсныг та бүхэн дуулсан байх. Гол үзүүлэлтийг хүргэе. Өөрийн хөрөнгийн өгөөж 2021 онд 23.2 хувь болж өссөн. 2022 оны нэгдүгээр улиралд бага зэрэг бууралттай харагдаж байна. Хөрвөх чадвар буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар. Компани өр төлбөрөө төлөх боломжтой юу гээд хямралын үед энэ их чухал байдаг. Санхүүгийн зохистой харьцаа доод тал нь 8 хувь байдаг бол манай бүрэн хангаж ажилладаг. Эрсдэлийн сангийн хүрэлцээн дээр багц хэрвээ эрсдэх юм бол түүнийг хангаад зогсохгүй илүү 1.1 тэрбум төгрөгөөр байгуулчихсан явж байна. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа бол 20 хувиас доош байж болохгүй гэдэг. Бид 20 хувиас дээш барьж зохистой харьцаагаа хангаж ажиллаж байна.

Хувьцааны арилжаа. Өнгөрсөн 52 долоо хоногийн дундаж бол 118-351 тэрбум төгрөгийн хооронд байлаа. Түүхэн дээд ханш буюу 351 төгрөгөнд 3 сард бид хүрч байсан. Нийт арилжааны дүн 10,7 тэрбум төгрөг. Хувьцааны арилжааны тоон үзүүлэлтүүд бол сүүлийн 12 сараар ярьж байгаа шүү. Зах зээлийн үнэлгээ бол энэ оны нэгдүгээр оны эцсээр хувьцааны үнээр тогтож 39.2 тэрбум, нийт арилжаалагдсан хувьцааны тоо 38,9 сая. 2021 оныг дангаар нь авч үзвэл нийт Ард Кредит компанийн гаргасан 280 сая ширхэг хувьцааны 100 сая нь эргэлтэд арилжаалагдсан. 20 тэрбум төгрөгний арилжаа явагдсан. Саяхан санхүүгийн шинжээч гаргасан байсан магадгүй хамгийн хөрвөх чадвартай хувьцаа ББС-ын салбартаа манайх байгаа. Нэгж хувьцаанд ногдох ашгаар 2021 онд 14 төгрөгтэй байлаа. Үнэ эздийн өмчийн харьцаа бол 15.7, үнэ бүртгэлийн үнэлгээний харьцаа бол 2.7 гэсэн үзүүлэлттэй байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг танилцуулахад түрүүн ТУЗ-ийн дарга маань хэллээ. Ард Санхүүгийн Нэгдэл бол дийлэнх хувьцааг буюу 40.57 хувийг эзэмшиж байна. Эхний 10-д орж байгаа хувьцаа эзэмшигчид 9.84, 5.15, 5.15 гэх мэтээр эзэмшиж байна. Бусад хувьцаа эзэмшигчид маань 56 сая ширхэг буюу нийт компанийн хөрөнгийн 20 хувийг эзэмшиж байна. 2021 оны эцсээр манай хувьцаа

эзэмшигчдийн тоо бол 13,702 болсон байна.

ТУЗ-ийг та бүхэнд танилцуулья. Бага зэрэг өөрчлөлтүүд орсон байгаа. ТУЗ-ийн даргаар Ч.Ганхуяг дарга хэвээрээ бол ердийн гишүүд О.Одбаяр, Ч.Ганзориг, Х.Батхишиг, Б.Ганбат, Г.Тэлмэн байна. Миний бие өнгөрсөн жилийн ХЭХ-аар ТУЗ орсон байгаа. Энэ нь компанийн засаглалын жишгээрээ ТУЗ-д дан ганц эзэд гэхээсээ илүүтэй компанийн ажилчидын менежментийн төлөөлөл байх ёстой гэдэг утгаараа орсон. Хараат бус гишүүнээр В.Ганзориг, Ч.Чинзоригт, Б.Солонго нар ажиллаж байна. Компанийн бүтцийг та бүхэнд товчхон танилцуулья. Өнөөдөр компанийн тухай хуулиараа компанийн эрх барих хамгийн дээд байгууллагаар ХЭХ болж байна. Түүнээс томилогдсон ТУЗ, ТУЗ-ийн дэргэд санхүү зээл эрсдэлийн хороо, аудитын хороо, засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо, аудитын хорооноос томилогдсон аудитор маань ажиллаж байна. Мөн гүйцэтгэх захирал. 4 газар, нэг албатайгаар компани ажиллаж байна. Зээлийн, санхүү удирдлагын, бизнес үйл ажиллагааны, эрсдэлийн удирдлагын газар, систем шинжилгээний алба гээд нийт 34 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Үүн дээр нэмэгдээд мэдээлэл технологийн, хууль хянан нийцүүлэх, хөрөнгө оруулалтын үйлчилгээг бид менежментийн үйлчилгээгээр Холдингс буюу Ард Санхүүгийн Нэгдэл компаниасаа авч Хүчтэй, Хамтдаа явдаг зохион байгуулалттай байгаа. Тайлан маань товчхондоо танилцуулаад дуусаж байна.

Ойрын ирээдүй буюу одоо хийж байгаа төслийг танилцуулахад Ard Kids апп-ын 2 дахь хувилбар, Ард апп-ын 5 дахь хувилбар, Good гээд та бүхэн 2 давхарт очоод харвал юун нарийн боовны дэлгүүр вэ гээд гайхаж магадгүй. Good гээд маргааш миний хувьд танилцуулах нэгэн платформыг бид хамтраад, үүсгэн байгуулагч санаачлагч компанитай явж байгаа. Энэ нь бол нийлүүлэлтийн гинжин хэлхээний шинэ төрлийн санхүүжилт бид олгож эхэлсэн гэсэн үг. Маргааш та бүхэн хуралдаа оролцоод миний танилцуулгаас ерөнхий мэдээлэл аваарай. Pick n Pay гээд шинэхэн үйлчилгээгээ маргааш танилцуулна. Нийт 1 сая харилцагчиддаа барьж байгаа хүүгүй, шимтгэлгүй, хувааж төлөх зээлийн бүтээгдэхүүн байгаа. Бид тогтвортой санхүүжилтийн холбоонд он гараад элслээ. Ингэснээр цаашдаа ногоон санхүүжилт авч түрүүн дурдсан Good платформын хүрээнд фермерүүд, аж ахуй эрхэлж байгаа, тэр салбарт ажиллаж байгаа хүмүүсийг санхүүжүүлэх бололцоо бүрдэнэ. Товчхондоо та бүхэнд компанийнхаа үйл ажиллагаа, санхүүгийн тайланг танилцуулаа. Баярлалаа.

4. Хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах

Танилцуулга хийсэн: Грант Торнтон Аудит ХХК-ийн Партнер Н.Эрдэнэцог

За энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Эрдэнэцог гэдэг. Грант Торнтон Аудит ХХК-ийн Аудитын Партнер. Та бүхэнд 2021 оны санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг товч танилцуулья.

Грант Торнтон Аудит бол Ард Кредит ББСБ-тай 2 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Аудитын ажлын цар хүрээ, аргачлал, дүгнэлт талаас яривал аудитор үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхдөө ямар үүрэг, хариуцлага хүлээх вэ? Нэгдүгээрт тухайн санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын дагаж мөрдөгдөж байгаа тодорхой үзэл баримтлалын дагуу бэлтгэгдсэн байна уу? Хоёрдугаарт тодорхой дүрэм, журмыг дагаж мөрдсөн байна уу? НББ хөтлөлт нь санхүүгийн тайлан гаргаж байгаа процесс нь дүрэм, журмынхаа дагуу байна уу? Зохицуулагч байгууллагаас гаргасан шаардлагыг дагаж мөрдөж байна уу? гэдгийг шалгаж дүгнэлт өгдөг. Компанийн удирдлагын үүрэг хариуцлага бол мэдээж холбогдох дүрэм, журам стандартынхаа дагуу санхүүгийн тайлангаа үнэн зөв гаргах үүрэгтэй. Санхүүгийн тайланг тайлагнадаг үйл явцдаа хяналт тавих. Санхүүгийн тайлан нь тасралтгүй байх зарчимтай байдаг. Манай аудитын баг бүрэлдэхүүн бол 68 өдөр 6 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Ер нь бол нэлээд удаан хугацаанд жилийн эцсийн аудитыг нь гүйцэтгэсэн.

Ер нь аудитын явцад ямар горимуудыг бид хийсэн бэ гэвэл Нэгдүгээрт компанийн удирдлагын баримталсан тооцоолсон нөлөө бүхий тооцооллууд буюу санхүүгийн тайланд үлэмж хэмжээний нөлөө үзүүлж байгаа тооцооллуудыг давтан шалгасан. Компани нь санхүүгийн тайлангаа гаргахдаа баримталж байгаа дотоод хяналт нь хэр зэрэг зохистой байгаа гэдгийг үнэлж үзсэн байгаа. Холбогдох анхан шатны баримтуудаараа гарч байгаа бүх ажил гүйлгээ нь нотлогдож байгаа эсэхийг тодорхой хэмжээнд түүврийн аргаар шалгадаг юм. Дүгнэлтээ гаргахдаа материаллаг байдал гэдэг зүйлийг

харгалзаж үздэг. Материаллаг байдал гэж юуг хэлж байгаа вэ гэхээр санхүүгийн тайланд бид дүгнэлтээ илэрхийлэхдээ ямар нэг материаллаг дүнгээр буруу илэрхийлэгдээгүй гэдэг агуулгыг илэрхийлдэг. Материаллаг байдал гэдгийг бид яаж үзсэн бэ гэхээр татвар төлөхийн өмнөх ашгийн 10 хувь юм уу, нийт орлогын 3 хувийг харьцуулж байгаад нийт 281 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон. Өөрөөр хэлбэл 281 сая төгрөгөөс доош байвал ямар нэг алдаа дутагдал байвал санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил гэж нөлөөлүүлж авч үзэхгүйгээр ерөнхийд нь бүхэлд нь дүгнэлтээ илэрхийлдэг гэж ойлгож болно.

Хараат бус байдлын хувьд аудитор тухайн байгууллагаас хараат бус ажилласан гэдгээ илэрхийлэх ёстой. Дотоод дүрэм, журмынхаа хүрээнд тухайн аудитын багт орж ажилласан хүмүүс маань тухайн байгууллагатай ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй ч гэдэг юмуу, хараат бусаар ажиллана гэдгээ илэрхийлж ажилладаг байгаа. Эцэс нь бол санхүүгийн тайлан дээр дүгнэлтээ илэрхийлсэн. Ард Кредит ББСБ ХК бол СТОУС-д нийцүүлэн, СЗХ-оос баталсан дүрэм, журмын хүрээнд 2021 оныхоо тайланг гаргасан байна гэж бид дүгнэлтээ илэрхийлсэн. Слайд дээр харагдаж байгаа бол хураангуй буюу сонин дээр илэрхийлэгдсэн дүгнэлтийг тавьсан байна. Аудитын тайлан бол энэ зузаан 50 гаруй хуудастай тайлан гардаг. Санхүүгийн үндсэн 4 тайлангаас гадна тодруулгатай. Та бүхэн компанийнхантайгаа холбогдоод тайлангаа дэлгэрэнгүйгээр нарийвчилж үзэж болох байгаа. Аудитын тайлангийн онцлох асуудал дээр юуг авч үзсэн бэ гэхээр Ард Кредит компани маань бол хувьцаат компани. Иймд НББ-ийн тухай хуульд зааснаар энэ компани маань бол санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэж гаргах үүрэгтэй. Гэвч өөрөө зохицуулалттай байгууллага учир СЗХ-оос баталсан дүрэм, журмын дагуу тайлан гаргах ёстой. Энэ хоёрын хооронд тодорхой хэмжээний зөрүү үүсдэг. Өөрөөр хэлбэл, юун дээр үүсдэг бэ гэхээр зээлийн үнэ цэнийн бууралт буюу түрүүн Тэлмэн захирал танилцуулсан СЗХ-оос баталсан Актив дахин ангилах журам гээд зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцдог энэ аргачлал маань СТОУС буюу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаас тодорхой хэмжээнд зөрүүтэй байдаг гэж үзэж болно. Цаашдаа уг компани маань хувьцаат компани учраас олон улсынхаа стандартын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж байх хэрэгтэй гэдэг дээр бид асуудлыг онцолж авч үзсэн байгаа. Аудитын тайлангийн гол асуудлын тухайд бол түрүүн дурьдсанчлан зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоолол компанийн удирдлагын зүгээс тодорхой шийдэл, тооцоолол ашигладаг учир энэ нь санхүүгийн тайланд үлэмж хэмжээгээр нөлөөлж байгаа асуудал юмаа гэдгээ аудитор 2021 онд 2.4 тэрбум төгрөгийн зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолсон байна гэж үзсэн. Ерөнхийдөө товч танилцуулахад ийм байна. Та бүхэндээ амжилт хүсье.

5. 2020 оны ногдол ашгийн тайлан, 2021 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах

Танилцуулга хийсэн: ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаяр

Грант Торнтон Аудит ХХК нь Ард Кредит ББСБ ХК-д сүүлийн 2 жил аудит хийж байгаа. Аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцууллаа. Одоо хурлын дэгийн дагуу 2020 оны ногдол ашгийн тайлан, 2021 оны ашгийн шийдвэрийг миний бие та бүхэнд танилцуулья.

2020 оны ногдол ашгийн тайлан. Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 01-ний өдрийн 2021/08 тоот тогтоол, 2021 оны 04 сарын 13-ний өдрийн 2021/12 тоот тогтоолуудаар компанийн 2020 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдээ нэгж хувьцаанд 3.57 төгрөг буюу цэвэр ашгийн 80.06 хувь болох 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг шийдвэрлэсэн байсан. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргаж, бүртгэлийн өдрийг 2021 оны 4 сарын 9-ны өдрөөр тогтоосон бөгөөд уг өдрөөр Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчид байгаа нийт хувьцаа эзэмшигчид ногдол ашиг олгосон байна. Компанийн зарласан ногдол ашгийг 2021 оны 6 сарын 30-ны өдөр багтаан СЗХ-оос өгсөн зөвлөмжийн дагуу ҮЦТХТ-өөр зуучлуулан 10,323 ширхэг хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлсэн. 2020 оны ногдол ашгийн тайланг танилцууллаа.

2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг мөн танилцуулья. Ард Кредит ББСБ-ын ТУЗ-ийн 2022 оны 2 сарын 18-ны өдрийн 2022/04 тогтоолоор компанийн 2021 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 4.5 төгрөг буюу цэвэр ашгийн 32.04 хувь болох 1 тэрбум 260 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар

шийдвэрлэсэн. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2022 оны ХЭХ-ын бүртгэлийн өдрөөр буюу 2022 оны 4 сарын 8-ны өдрөөр тогтоосон. 2022 оны 4 сарын 8-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээгээр 13,208 хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй байна. Бид ногдол ашгийг ҮЦТХТ-өөр зуучлуулан 2022 оны 7 сарын 1-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлнэ гэсэн шийдвэрийг ТУЗ-өөс гаргасныг дуулгая.

6. ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах

Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Чинзоригт гэдэг. Би 2012 онд Америкийн нэгдсэн улсын Utah мужийн их сургуульд санхүүч мэргэжлээр. 2021 онд Их Засаг их сургуулийг Эрхзүйч мэргэжлээр тус тус төгссөн бөгөөд 2012 оноос хойш Моннис Интернэйшнал компанид ажилд орон дэвшин ажилласаар өнөөдөр Моннис Моторс компанид Гүйцэтгэх захирлын алба хашиж байна. Би Ард Кредит ББСБ ХК-д 2020 оны 7 дугаар сард ТУЗ-ийн түр гишүүн, 2021 оны 4 сарын ХЭХ-аар ТУЗ-ийн хараат бус гишүүн, 2021 оны 7 сард ТУЗ-ийн хурлаар Дотоод аудитын хороо болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд тус тус томилогдон ажиллаж байна.

Өнөөдөр би та бүхэнд 2021 оны Ард Кредит ББСБ-ын ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагааны ерөнхий тайлан, ТУЗ-өөс гаргасан чухал шийдвэрүүд болон үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг танилцуулна.

Ард Кредит ББСБ нь 3 хороотой бөгөөд ТУЗ-ийн даргаас гадна 9 гишүүдтэй. Үүний 3 нь хараат бус гишүүд байгаа нь Компанийн засаглалын кодекс, Компанийн тухай хууль болон Компанийн дотоод дүрэмд нийцэж байгаа юм. ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирал Чулууны Ганхуяг ажиллаж байгаа бол Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн В.Ганзориг, гишүүдээр Ч.Чинзоригт, Б.Ганбат нар ажиллаж байна. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар О.Одбаяр, гишүүдээр Х.Батхишиг, Б.Ганзоригт, Ч.Чинзоригт болон Солонго нар ажиллаж байна. Санхүү, зээлийн эрсдэлийн хорооны даргаар Ч.Ганзориг, гишүүдээр Б.Ганбат болон Г.Тэлмэн буюу Ард Кредит ББСБ-ын Гүйцэтгэх захирал нар ажиллаж байна.

Та бүхний харж байгаачлан ТУЗ нь Монголын банк, санхүү, хөрөнгө оруулалтын салбарт олон жил ажилласан туршлагатай, нийгэмд танигдсан олон гишүүдээс бүрдэж байгааг хэлэхэд таатай байна. 2021 онд ТУЗ нь нийт 4 удаа хуралдаж, 23 удаа эчнээ санал хураалт авч, нийт 72 шийдвэрийг амжилттай гаргасан. 2021 онд гаргасан ТУЗ-ийн чухал шийдвэрүүдийг дурдвал 2020 оны цэвэр ашгаас 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараах, халаасны хувьцааг эргэлтэд гаргах, хаалттай бонд гаргах, Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авах, компанийн үйл ажиллагаагаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан 2 салбарыг нээх, 2022 оны төсөв, бизнес төлөвлөгөөг батлах зэрэг шийдвэрүүд байна.

Ард Кредит ББСБ ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг танилцуулья.

Ард Кредит ББСБ нь 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. ТУЗ нь тайлант онд компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, улирал бүр компанийн гүйцэтгэлийн үр дүнг хэлэлцэж, стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд нь хяналт тавих, ерөнхий удирдлагаар хангахын зэрэгцээ гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж ажилласан. Бид ТУЗ-ийн эрх, үүргээ хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдах, харилцагчийн эрх ашигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх, хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөн ажиллаж ирлээ.

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь COVID-19 цар тахлаас үүдэлтэй тодорхойгүй нөхцөл байдалд ажиллаж, Засгийн Газрын тогтоол, шийдвэрүүд, зохицуулагч байгууллагуудаас гаргасан журмыг

даган мөрдөж, цар тахал эрчимтэй нэмэгдэж байсан үед ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа онлайн хэлбэрт шилжүүлж, зайнаас ажиллаж харилцагч, хувьцаа эзэмшигчиддээ үзүүлэх үйлчилгээгээ тасралтгүй хүргэж ажилласан.

Өнгөрсөн 2021 онд Ард Кредит ББСБ ХК нь 594 тэрбум төгрөгийн төлбөрийн үйлчилгээг Ард Апп-аар дамжуулан Монголбанкнаас олгосон Цахим мөнгөний тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлсэн ба Цахим мөнгөний журам 2021 оны 12 дугаар сард өөрчлөгдөхөөс өмнө харилцагчийн нэг өдрийн гүйлгээний хязгаар 3 сая төгрөг байсан нь харилцагчдын санхүүгийн хэрэгцээг хангах, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд хамгийн том бэрхшээлийн нэг байсан юм. Бидний зүгээс Монголбанкт харилцагчдын гомдол, үйл ажиллагаанд үүсэж буй хүндрэл бэрхшээлийн талаар удаа дараагийн уулзалт, хэлэлцээр хийж харилцагчдын гүйлгээний хязгаарыг нэг удаа 5 сая төгрөг, өдрийн хязгаарлалтгүй болгоход өөрсдийн хувь нэмрээ оруулж ажилласан. Бидний 2021 онд үзүүлсэн үйлчилгээ нь банктай өрсөлдөхүйц үзүүлэлт бөгөөд цаашид харилцагчдынхаа санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг улам нэмэгдүүлэх, тэдний хэрэгцээнд нийцсэн төлбөрийн карт гаргах тусгай зөвшөөрлийн хүсэлтээ Монголбанкинд холбогдох хууль, журмын дагуу гурван удаа хүргүүлсэн ч одоог хүртэл татгалзаж, шударга өрсөлдөх боломжийг хаасаар байна.

Цахим шилжилт, блокчэйн технологийн хурдацтай хөгжлийн нөлөө 2021 онд дэлхий даяар эрчимтэй тархаж, хүний өдөр тутмын амьдралын хэрэглээнд нэвтэрч, санхүүгийн салбарын хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болсоор байна. Манай улсад ч гэсэн дээрх үзэгдэл нөлөөлснөөр шинээр койн гаргах, виртуал хөрөнгийн бирж нээх, хөрөнгө оруулалтын шинэ төрлийн бүтээгдэхүүн нэмэгдэх, хөрөнгийн биржийн үйл ажиллагаа эрчимжиж, хөрөнгө оруулалтын сонирхол нэмэгдэхэд эерэг олон сайн өөрчлөлт авчирсан ч цахим хэлбэрийн залилангийн үйлдэл нэмэгдэж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний бүрэлдэхүүн компаниудын харилцагчиддаа олгосон урамшууллын оноог цахим орчинд хуурамч хаяг үүсгэн төөрөгдүүлэх замаар залилан мэхэлж, удаа дараа хохирол учруулсан үйлдлүүд гарсан бөгөөд бид буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, хохирлыг барагдуулахаар Цагдаагийн байгууллагатай хамтран ажилласаар байна.

ТУЗ нь улирал бүр тогтмол ээлжит хурал, богино хугацаанд шийдвэр гаргах асуудлаар эчнээ санал хураалтыг зохион байгуулж, холбогдох тогтоол шийдвэрийг гарган ажиллаж ирсэн бөгөөд өнгөрсөн жил 4 удаа ээлжит, 53 удаа эчнээ санал хураалтаар 72 шийдвэр гаргаж ажилласан байна. ТУЗ-өөс гаргасан онцлог шийдвэрүүдээс дурдвал 2020 оны цэвэр ашгаас 1.0 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараах, Хаалттай бонд гаргах, Халаасны хувьцаа эргэлтэд гаргах, Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авах шийдвэр, Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан 2 салбар байгуулах, 2022 оны төсөв, бизнес төлөвлөгөөг батлах зэрэг компанийн үйл ажиллагааг зөв зохистой удирдахад нөлөөлөхүйц томоохон шийдвэрүүдийг гаргаж ажиллажээ.

2021 онд Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд дэвшиж, компанийн нэгж хувьцааны үнэ түүхэн дээд ханш болох 351.12 төгрөгт хүрч, зээлийн багц 20.3 тэрбум төгрөгөөс 36.6 тэрбум төгрөгт хүрсэн, нийт актив 73.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 247 хувиар өссөн, 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 13,702 хувьцаа эзэмшигчтэй болсон нь өнгөрсөн 10 жилийн түүхэндээ хамгийн өндөр өсөлт үзүүлсэн жил байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж 2021 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэн ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

Уг дүгнэлтийг ТУЗ-ийн 2022 оны 4 сарын 15-ны өдрийн 2022/13 тогтоолоор баталсан болно. Үүгээр миний танилцуулах хэсэг өндөрлөж байна. Баярлалаа.

7. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах
Танилцуулга хийсэн: Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн

Маш товчхон зүйл байгаа. Дүрмийн өөрчлөлт дээр ноцтой зүйл бол байхгүй. Сайхан мэдээ дуулгахад бид Тэнгэрлиг медиа орчихсон байгаа хойд талын Өнгөт хэвлэлийн байранд олон жил байсныг мэдэж байгаа. Ийнхүү бид буурь сэлгэж компанийн үйл ажиллагаа өргөжиж байгаатай холбоотой Централ таурын 13 давхарт 1313 тоот руу орсон. Энэ нь компанийн дүрэмд байгаа албан ёсны хаягийг өөрчлөх өөрчлөлт байгаа. Шинээр орж байгаа өөрчлөлт нь 1.6 дээр Компанийн албан ёсны хаяг маань Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Централ таур барилгын 13 давхар, 1313 тоот. Утас: 77003322 гээд ийм өөрчлөлтийг оруулж байгаа юм.

8. Давуу эрхийн хувьцаа, хоёрдогч өглөг гаргахыг танилцуулах

Танилцуулга хийсэн: Санхүү эрхэлсэн захирал Х.Билгүүн

Сайн байцгаана уу, Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнтэйгээ уулзаж байгаадаа их баяртай байна. Миний хувьд мөн адил та бүхэнтэйгээ анх удаагаа уулзаж байна. Өөрийгөө товчхон танилцуулахад намайг Билгүүн гэдэг. Ард Кредит ББСБ-ын Санхүү эрхэлсэн захирлаар өнгөрсөн оны 12 дугаар сараас эхлэн ажиллаж байна. Одоогоор 5 сар орчин ажиллаж байна. Одоо миний бие 2 асуудлыг танилцуулна. Манай ТУЗ-ийн даргын хэлсэнчлэн Компанийн хувьд болон Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд түүхэн шийдвэрийг гаргах ёстой. Уг шийдвэрийг та бүхэнд танилцуулах гэж байгаадаа их баяртай байна.

2021 он бол Компанийн түүхэнд үсрэнгүй хөгжилтэй жил байлаа. Бидний хувьд одоогийн байгаа эздийн өмч буюу өөрийн хөрөнгийн хэмжээ, бүх нөөц бололцоогоо шавхаж нийт хөрөнгөө өсгөсөн байгаа. 73 тэрбум төгрөгт хүргэсэн гэж Гүйцэтгэх захирал түрүүхэн дурдлаа. Цаашлаад бид бүхэн дараагийн сорилттойгоо буюу дараагийн түүхэн он жилүүдтэйгээ уулзах гэж байна гэж хүлээж байна. Компанийг дараагийн төвшинд гаргах, хөгжлийг улам хурдасгах, активын хэмжээг хурдтай тэлэхэд бидний зайлшгүй хийх шаардлагатай нэг зүйл бол өөрийн эздийн өмчийг өсгөх. Эздийн өмчийг өсгөхийн тулд 2 зүйлийг хөрөнгийн зах зээл дээр танилцуулж байна. Эхнийх бол Давуу эрхийн хувьцаа гаргах. Энэхүү үйлчилгээ нь ямар нөхцөлтэй бэ? гэхээр хугацааны эцэст энгийн хувьцаанд хөрвөнө. Тэр нь 3 жилийн тутам буюу 3 сарын дотор энэхүү давуу эрхийн хувьцаагаа гаргаснаас хойш энгийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлөө хувьцаа эзэмшигч маань эдэлнэ. Биржийн зах зээл дээр нээлттэй гаргана. Одоогийн байгаа энгийн хувьцаа буюу 280 сая ширхэг хувьцааныхаа 15 хувьтай тэнцэх 42 сая ширхэг хувьцааг зах зээлд танилцуулна. Энгийн хувьцаанаас давуу эрхийн хувьцаанд үүсэж байгаа гол ялгаатай давуу тал бол жилийн тогтмол 15 хувийн өгөөжийг нийт хөрөнгө оруулагч нартаа санал болгож байгаа байдал. Ерөнхийдөө хувьцаанаас 2 төрлөөр ашиг хүртэж болдог. Энэ нь ногдол ашиг, ханшийн зөрүүний ашиг. Давуу эрхийн хувьцаагаар нэг ашгийг нь шууд өгчхөж байгаа гэсэн үг. Компани жил бүр танд 15 хувийн өгөөжийг санал болгоно. Ийм давуу талтай хувьцааг танд санал болгож байна. Хувьцаа эзэмшигч та бүхэнд илүү дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн байгаа учир танилцуулгаа товчлоод дараагийн бүтээгдэхүүн рүү орьё.

Дараагийнх нь мөн Хоёрдогч өглөг. Зорилго нь мөн адил эздийн өмч нэмэгдүүлэх. Эздийн өмчийг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ. Үүнийг дагаад актив томрох, компани өсөх боломж тус тус нээгдэнэ. Улмаар ашигт ажиллагаа нэмэгдэх, компанийн үнэ цэнэ, нэгж хувьцааны ханш өсөх, та бүхний оруулсан хөрөнгө оруулалт өгөөж нэмэгдэх зэрэг үр дүн хүлээж байгаа гэж тооцож байна. 5 тэрбум төгрөгийг 5 жилийн хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй, хувьцааны эцэст хөрвөх нөхцөлийг ХЭХ-аар шийдвэрлэх ерөнхий нөхцөлтэйгээр гаргахаар болж байгаа. Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхнийг энэхүү 2 асуудлыг маань дэмжинэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Хөтлөгч: Санхүү эрхэлсэн захирал Билгүүнд баярлалаа. Хурлын дэгийн дагуу бидний хэлэлцсэн, Гүйцэтгэх захирлын тавьсан танилцуулга, Аудитын компанийн дүгнэлт, ТУЗ-ийн дүгнэлт, Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн тухай, Давуу эрхийн хувьцаа, Хоёрдогч өглөгийн тухай танилцуулсан асуудлуудтай холбоотойгоор асуух асуулт, хариул авах цаг болсон байна. Та бүхэнд асуулт байна уу?

9. Хэлэлцэх асуудалтай холбоотой, асуулт хариулт

Асуулт асуусан1: ХЭХ-ыг амжилттай сайхан зохион байгуулж буй залуучууд та бүхэнд баяр хүргэе. Үүн дээр нэг зүйлийг асууя. Ногоон зээлийн асуудал гэж яригдаж байна. Энэ дээр залуучууд тодорхой хэмжээгээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа учир тэдэнд олдох боломжтой байх. Тэгвэл тэтгэврийн

бидэнд ямар журмаар, яаж явагдах бол гэсэн асуулт байна. Улаанбаатар хотод байртай мөртлөө эрүүл агаарт зуслантай болох сонирхол байгаа. Энэ тал дээр ямар дэмжлэг үзүүлж, ямар ажиллагаа, ямар хугацаатай явагдах вэ?

Гүйцэтгэх захирал Тэлмэн: Үүн дээр нөхцөл, журам талаар нарийн мэдээлэл өгөхөд эрт байна. Тогтвортой санхүүжилтийн холбоонд бид элссэн байгаа. Ингэснээрээ бид ногоон зээлийг гаргаж боломжууд бүрдэнэ. Компанийн хувьд тодорхой хэмжээний санхүүжилт татдаг, түүгээрээ зээл олгодог. Уг холбоонд нэгдсэнээр цаашдаа таны ярьсан ногоон санхүүжилтийг хийхийн тулд эх үүсвэрийн татсанаараа боломж нь бүрдэнэ. Иймд өнөөдөр яг тийм бүтээгдэхүүн гаргана гэж ярьхад эрт байна. Гэхдээ өнөөдөр Scora гээд Good платформын хүрээнд үйлдвэрлэгчид, тариаланчдад бага хүүтэй санхүүжилтийг бид зориг гаргаад олгоод эхэлсэн. Таны ярьж байгаа бүтээгдэхүүнийг яг хэзээ, ямар нөхцөлтэй гаргана гэж ярьхад эрх байна.

Асуулт асуусан2: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Дархан-Уул аймгаас оролцож байгаа Мөнхөө гэж хүн байна. Надад хэд хэдэн асуулт байна.

Ногдол ашиг 4 төгрөг 50 мөнгө гэсэн үү? Заавал 4 сарын 8-нд гарсан тогтоолын дагуу ногдол ашиг өгөх гээд 6,7 сар болох шаардлага байна уу? Одоо ингээд 5 сард өгчхөж болохгүй юу?

Давуу эрхийг хувьцаан дээр 1 хувьцаа хэдэн төгрөг гэж тогтоосон зүйл байна уу?

Кредит картын асуудал дээр Монгол банканд 3 удаа албан бичиг өгөөд бүтсэнгүй гэж байна. Үүн дээр илүү шуурхай ажиллаж болохгүй юу? Та бүхэн амжилт хүсье. Монголчууд эвтэй байхдаа хүчтэй шүү.

Гүйцэтгэх захирал Тэлмэн: Ногдол ашгийн хувьд бүртгэлийн өдөр 4 сарын 8, 6 сарын 30-ны өдөр хүртэл тараана гэж байгаа. Эцсийн өдөр 6.30 хүртэл. Тэрнээс өмнө бол тараана. Өнгөрсөн жилийн хувьд Хөрөнгийн бирж дээр 2020 оны ногдол ашгийг 2021 онд тараахдаа Ногдол ашиг тараах шийдвэр гаргасан компаниудаас хамгийн түрүүнд манай компани олгосон байдаг. Зарим компаниуд 11,12 сар хүртэл олгосон тохиолдолд байдаг. Эцсийн хугацаа 6 сарын 30 гэж байгаа тул түүнээс өмнө мөн олгогдоод явна гэсэн хариулт өгөхөөр байна.

2 дахь асуулт нь Давуу эрхийн хувьцааны үнийн талаар асууж байна. Үүн дээр Санхүү эрхэлсэн захирал Билгүүн хариулна. Кредит картын асуудал яах аргагүй жил өнгөрөөд явж байна. Кредит карт гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас олгодог. Бид он гараад дөнгөж эхний хүсэлтээ өгөөд түүний дараа 2,3 удаа буцаагдах хариултууд ирсэн. Бид Монголбанктай хамтарч ажиллаад өөрсдийн зүгээс сайжруулах зүйлсүүдийг хийж байгаа. Гэвч ирсэн албан тоотуудыг харахад нэлээн субъектив байдалтай, Монголбанкнаас тодорхой шатанд манайд олгохгүй гэж зорьж байгаа юм шиг өнгө аяс мэдэгдэж байна. Энэ хугацаанд Монголбанкны карт гаргагчийн журам мөн өөрчлөгдсөн байдаг. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалаад Монголбанк хянан шалгах хугацаагаа хэтрүүлсэн асуудал ч байна. Бидний хувьд зарим зүйлийг цаг хугацаанд нь өгөөгүй гээд 2 талдаа асуудал байсан. Шинэ журмаар энэ жилийн 7 сарын 10-наас хойш Кредит карт гаргах зөвшөөрлөө өгөх болж байгаа. Яг одоогоор 3 удаа ийм нөхцөл байдалтай байгаа тул 7,8 сард баттай гарна гэж амлахад хэцүү байна. Монголбанкны зүгээс танайх бусад асуудлуудаа хангачихсан, олгоход татгалзах зүйлгүй гэдгээ албан бусаар мэдэгдсэн.

Санхүү эрхэлсэн захирал Билгүүн: Давуу эрхийн хувьцааны хувьд ерөнхий нөхцөлийг танилцуулсан. Цаашид бид бүхэн ажиллагаа хийнэ. Ер нь бол хөндлөнгийн үнэлгээний компани тогтоох юм. Үнэлгээний компани ажиллагаа хийгдэх үед зах зээл дээрх энгийн хувьцааны үнэ ямар байхаас хамаарч, уг үнэтэй уялдуулан нэг давуу эрхийн хувьцаа хэдэн энгийн хувьцаанд хөрвөх боломжтой гэдгийг үнэлгээний компани тогтоосноор нэг давуу эрхийн хувьцааны үнэ эцэслэж тогтоогдоно.

Асуулт асуусан3: Нэг асуулт байна. ТУЗ-ийн даргын ярианаас сонсоход Компанийн гаргасан тайлан, ОУС хоёрын хоорондын зөрүүнээс 2.4 тэрбум төгрөгийн үнэ цэнийг алдсан гээд зөрүү ярьж байна. Энэ нь ямар учиртай вэ?

ТУЗ-ийн дарга Ганхуяг: Аудит хийлгэхээр аудиторууд тодорхой хэмжээний залруулгууд оруулдаг. Үүн дээр зарчмын зөрүүтэй асуудлууд гарч ирж байгаа. Гэвч энэ нь компанийн хувьд шууд алдагдал хүлээчихсэн зүйл байхгүй. Зөвхөн бүртгэлтэй холбоотой асуудлууд гарч байгаа. Маш олон асуудлууд

байдаг.

Асуулт асуусан4: Тэлмэн захирлаас асуух нэг асуулт байна. Ирэх оны төсөөлөл /санхүүгийн/ ямар байгаа вэ? Сая Монголбанкнаас бодлогын хүү нэмчих шиг боллоо. Үүнтэй холбоотойгоор ямар нэг эрсдэл гарах уу?

Гүйцэтгэх захирал Тэлмэн: Макро орчин бол муу байгаа. Нэг өрхийн зардал 1.4 сая байхад цалингийн орлого 1 сая төгрөг ч байдаг юм уу. 400 мянган төгрөгийн дутагдалтай явж байна. Энэ ч гэсэн 1 дүгээр улирлын зээлийн эргэн төлөлт дээр харагдаж байгаа. Ер нь нэлээд таатай орчинд ажиллахгүй. Өнгөрсөн жилүүдэд ч таатай орчинд ажиллаагүй. Энэ жилийн бидний зорилго бол Тогтвортой өсөлт, тооноос чанарт гэж байгаа. 1 сая харилцагчтай болсон ч түүний 5 хувь л манайхаас тодорхой хэмжээнд зээл авсан. Гэвч 1 дүгээр улиралд харахад өмнөх оны үеэс хүү, шимтгэлийн орлого, үндсэн үйл ажиллагааны орлогууд өсөлттэй. Гол сорилт бол мэдээж актив ангиллын журам бол буцаад хуучин ангилал руугаа орсон. 1 сар гарангуут хугацаа 60 хоног дотор хугацаа хэтэрсэн зээл хэвийн гэж ангилдаг байсан бол шууд 30 хоног болгосон. Ингээд манай эрсдэлтэй зээлийн багц 10-15 хувь болсон. Үүн дээр үндэслээд эрсдэлийн сангаа нэмэгдүүлсэн. Энэ жил өнгөрсөн жилийнхээ амжилтыг давтана гэсэн зорилготой байна. Макро орчин, хил, гааль бүх юмыг тооцож үзсэн ч хэд дахин өсөлтүүдийг гаргахад нэлээн хүнд.

Бодлогын хүү он гарснаар 2 удаа өсөөд 9 болчихлоо. Банк санхүүгийн салбарт харахад банкны хувьд хүртэл хадгаламжийн хүү 10 боллоо. Банкны эх үүсвэрийн өртөг 14,15 хувь руу орчихож байгаа. Манайх ч гэсэн сая гаргасан бондын хүүгээ ч гэсэн нэмэгдүүлэх шаардлага гарсан. Нэг талаараа эх үүсвэрийн зардал өсөөд байгаа ч бид зээлийн хүүгээ өсгөхгүй байх бодлого баримтल्या гээд явахад ашигт ажиллагаа буурна. Тэр утгаараа банкууд ч гэсэн бодлогын хүү өөрчлөгдсөний маргааш зээлийн хүүгээ нэмсэн. Манай хувьд мэдээж гол ашигт ажиллагаа өндөртэй бүтээгдэхүүнүүд дээрээ төвлөрч ажиллах төлөвлөгөөтэй байна. Яагаад гэвэл эх үүсвэрийн зардал өсөөд, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа тул түүнийгээ нөхөх хэрэгтэй.

10. Саналын хураалтын дүнг нэгтгэх, танилцуулах

Танилцуулга хийсэн: Тооллогын комиссын дарга Г.Алтансүх

Тооллогын комиссын дарга Алтансүх:

Сайн байцгаана уу, Ард Кредит ББСБ ХК-ийн ХЭХ-ын Ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолын танилцуулья.

Тогтоол2. 2022 оны 4 сарын 30-ны өдөр Тооллогын комиссын тогтоолын дугаар 2022/02 Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн Тогтоох нь: Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай санал хураалтад 227,664,474 ширхэг буюу 81.3 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- Зөвшөөрсөн 213,528,726 ширхэг буюу 93.79 хувь,
- Татгалзсан 1,000 ширхэг, 00 хувь,
- Түдгэлзсэн санал байхгүй. Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсгийн үндэслэн шийдвэр хүчинтэй байна.

Тогтоол3. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэхь хэсгийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон, болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн Тогтоох нь: Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан, нэгдүгээр хавсралтаар батлах тухай санал хураалтад 227,664,474 ширхэг буюу 89.36 хувийн хувьцаа эзэмшигч оролцсоноос:

- Зөвшөөрсөн 225,206,658 ширхэг буюу 98.92 хувь
- Татгалзсан 8,100 ширхэг, 0,004 хувь,
- Түдгэлзсэн санал байхгүй. Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсгийн үндэслэн шийдвэр хүчинтэй байна.

Тогтоол4. Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 болон 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсгийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон Ард Кредит ББСБ ХК-ийн эздийн өмчийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт татах зорилгоор Давуу эрхийн хувьцаа гаргахыг зөвшөөрөх тухай санал хураалтад 227,660,474 ширхэг хувьцаа эзэмшигч оролцсоноос:

- Зөвшөөрсөн 224,674,223 ширхэг буюу 98.68 хувь
- Татгалзсан 197,122 ширхэг буюу 0.08 хувь
- Түдгэлзсэн 442,629 ширхэг буюу 0.19 хувь байна. Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсгийн үндэслэн шийдвэр хүчинтэй байна.

Тогтоол5. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11 дахь хэсгийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон Ард Кредит ББСБ ХК-ийн эздийн өмчийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт татах зорилгоор Хоёрдогч өглөг гаргахыг зөвшөөрөх тухай санал хураалтад сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн 36,628,318 ширхэг хувьцаа эзэмшигч оролцсоноос:

- Зөвшөөрсөн 32,939,712 ширхэг буюу 89.93 хувь
- Татгалзсан 74,739 ширхэг буюу 0.02 хувь
- Түдгэлзсэн 441,931 ширхэг буюу 1.20 хувь байна. Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсгийн үндэслэн шийдвэр хүчин төгөлдөр боллоо.

Хөтлөгч: Алтансүх захиралд баярлалаа. ХЭХ-ын тогтоолыг та бүхэнд танилцуулья.

Тогтоол 1. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тооллогын комиссын 22/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

Тогтоол 2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тооллогын комиссын 22/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг нэмэлт, өөрчлөлт оруулан нэгдүгээр Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан дүрмийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэн хянуулж, Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

Тогтоол 3. Давуу эрхийн хувьцаа гаргахыг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 болон 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 22/04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн эздийн өмчийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт татах зорилгоор хавсралтад заасан нөхцөлөөр давуу эрхийн хувьцаа гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж давуу эрхийн хувьцаа гаргах хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

Тогтоол 4. Хоёрдогч өглөг гаргахыг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11 дахь хэсэг, 2022 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 22/05 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн эздийн өмчийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт татах зорилгоор

хавсралтад заасан нөхцөлөөр хоёрдогч өглөг гаргахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж хоёрдогч өглөг гаргах хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

Тогтоолуудыг саяын санал хураалтаар гишүүд санал өгч баталжээ. Ингээд тогтоолын төслийг та бүхэндээ уншиж танилцууллаа. Ард Кредит ББСБ ХК-ийн ХЭХ өнөөдөр хэлэлцэх асуудлаа амжилттай хэлэлцэж баталлаа. Нийт хуралдаа ирсэн нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын багийн хамт олны өмнөөс талархал илэрхийлж, цаашдын ажил, амьдрал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

ХУРЛЫН ДАРГА:

Ч.ГАНХУЯГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ОЮУНБААТАР